ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2020/120/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас:70584203 Цахим хаяг:Bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 70584204 Цахим хаяг:Tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 70584207 Цахим хаяг:Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ДОА | Дорнод аймаг |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| БСУГ | Боловсрол, соёл, урлагийн газар |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ....3
2.1. Оршил ....5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....9
2.12. Шилэн дансны мэдээлэл ....9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....9
Менежментийн захидал ....10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ....11
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ....11
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....11
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ....13
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан ....15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....16

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.14 № 72

танай ____________-ны №______________-т

ХЭРЛЭН СУМЫН 9 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ДЭЛГЭРМАА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520274

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Г.Дэлгэрмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн бараа материалын анхан шатны баримтыг хөтлөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 14–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Байгууллагын ажилтан бүр хүүхдийн бүтээж эзэмшихүйн танин мэдэхүйг хөгжүүлэхэд түүчээлнэ “ гэж тодорхойлжээ.

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох
- Хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох
- Хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд 10 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 338,579.9 мянган төгрөгөөс тооцон 6,771.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,467.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,183.9 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Бараа материал болон үндсэн хөрөнгийн дансанд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 59,924.7 | 47,390.7 | -12,534.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,088,151.2 | 1,107,825.4 | 19,674.2 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | -9,217.7 | -48,541.7 | -39,324.0 |
| **Нийт хөрөнгө** | 1,138,858.2 | 1,106,674.3 | -32,183.9 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,138,858.2 | 1,106,674.3 | -32,183.9 |
| Өмнөх үеийн үр дүн | 898,886.4 | 898,886.4 | 0 |
| Тайлангийн үеийн үр дүн | | -32,183.9 | -32,183.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 126,546.8 | 126,546.8 | 0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,138,858.2 | 1,106,674.3 | -32,183.9 |

Авлага, өглөгийн үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь бусад хангамжийн материал 13,433.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Энэ нь 2019 онд тус байгууллагад санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийж бусад хангамжийн материалд байсан хөрөнгийг үндсэн хөрөнгөд авах зөвлөмж өгч зөвлөмжийн дагуу хасаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансанд 2019 онд 94,812.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 93,912.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь бараа материалын данснаас хөрөнгө шилжүүлж, БСУГ болон эцэг эхийн хандиваар хөрөнгө авснаас шалтгаалжээ.

Энэ нь хөрөнгө оруулалтаар 840.0 мянган төгрөг мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 5,400.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,106,674.3 мянган төгрөг болж 32,183.9 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн өндөр байгаатай холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус цэцэрлэгийн хувьд орлогын төлөвлөгөөг баталж өгөөгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 471,255.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 471,255.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 438,370.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 32,884,3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466,463.8 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Цахим тендерийн баримт бичгийн үнээс 247.5 мянган төгрөгийг олж нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс тендерийн бичиг хэргийн зардалд 247.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33,930.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 148.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 32,799.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 983.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 32,947.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 148.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 32,799.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн 30,091.0 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт ”Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2017 оны 349 дүгээр тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв

2. Бараа материалын зарлагын гүйлгээг анхан шатны бүртгэлтэй тулган шалгахад 2708.5 мянган төгрөгийн шаардах хуудсыг бүрэн хөтлөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Бараа материалын түүвэр тооллого хийх явцад харилцагч компаниас 148.1 мянган төгрөгийн бараа материалыг дутуу авч нягтлан бодох бүртгэлд тусган, авлагаар бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

Аудитаар илэрсэн 983.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авалтын е баримтыг баримтад хавсарган, анхан шатны бүртгэлийг бүрэн хөтлөхөд анхаарах шаардлагатай.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Хандив, тусламжийн орлогын талаар*

1.1. *Илрүүлэлт*:Цалингийн зардлаас НДШ-д 983.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

1.2. *Эрсдэл*: Тайлан буруу илэрхийлэгдэх.

*1.3. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **59924726,50** | **47390749,50** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0,00 | 0,00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 59924726,50 | 47390749,50 |
| 351 | **Түүхий эд материал** | 0,00 | 0,00 |
| 354 | **Хангамжийн материал** | 59924726,50 | 47390749,50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 194345,00 | 194345,00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1413500,00 | 1413500,00 |
| 35460 | Хүнсний материал | 0,00 | 0,00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 58316881,50 | 45782904,50 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1078933527,88** | **1059283600,28** |
| 37 | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0,00 | 0,00 |
| 371 | **Урт хугацаат хадгаламж** | 0,00 | 0,00 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1078933527,88 | 1059283600,28 |
| 391 | Газар | | |
| 392 | **Биет хөрөнгө** | 965046527,80 | 945550600,16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 883520596,40 | 883520596,40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0,00 | -22645343,76 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40381533,00 | 44922432,00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -4872403,50 | -12174815,22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40972254,50 | 56105431,50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3770685,96 | -11414744,16 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9081900,00 | 9081900,00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -266666,64 | -1844856,60 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 113887000,08 | 113733000,12 |
| 39301 | Програм хангамж | 770000,00 | 770000,00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -307999,92 | -461999,88 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 113425000,00 | 113425000,00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1138858254,38** | **1106674349,78** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0,00** | **0,00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0,00 | 0,00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1138858254,38** | **1106674349,78** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1138858254,38 | 1106674349,78 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 113425000,00 | 113425000,00 |
| 51101 | Өмч: - төрийн | 113425000,00 | 113425000,00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 898886371,37 | 866702466,77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 832764059,47 | 898886371,37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 66122311,90 | -32183904,60 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 126546883,01 | 126546883,01 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1138858254,38** | **1106674349,78** |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **489532218,50** | **491176576,00** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0,00** | **0,00** |
| 110 | **Орлогын албан татвар** | 0,00 | 0,00 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **87563931,50** | **344959600,00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 19405887,00 | 0,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19405887,00 | 0,00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19405887,00 | 0,00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 64876144,50 | 0,00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 64876144,50 | 0,00 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | | |
| **122** | **Тусламжийн орлого** | 3281900,00 | 0,00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3281900,00 | 0,00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | | |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 0,00 | 344959600,00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 0,00 | 344959600,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **401968287,00** | **146216976,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 393695500,00 | 93411100,00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 393695500,00 | 93411100,00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8272787,00 | 19921576,00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0,00 | 19674076,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200000,00 | 0,00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8072787,00 | 247500,00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0,00 | 32884300,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0,00 | 32884300,00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **423409906,60** | **523360480,60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **423409906,60** | **523360480,60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 423403472,60 | 518369287,60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 249978365,62 | 304978655,00 |
| 210101 | Үндсэн цалин | 217643488,62 | 267242714,00 |
| 210102 | Нэмэгдэл | 13326831,00 | 9746590,00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 19008046,00 | 27989351,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30051455,38 | 38124400,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20002349,99 | 25924600,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2262788,00 | 3050100,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2013973,00 | 2508115,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 712608,00 | 541785,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5059736,39 | 6099800,00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23742566,00 | 26710170,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4752282,00 | 5065962,00 |
| 210302 | Түлш, халаалт | 9471443,00 | 10773827,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9518841,00 | 10870381,00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3723300,00 | 16401449,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 650000,00 | 787500,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1400000,00 | 380000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 632000,00 | 699972,00 |
| 210404 | Ном, хэвлэл | 348000,00 | 0,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0,00 | 100000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 693300,00 | 1000000,00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0,00 | 13433977,00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2105** | **Нормативт зардал** | 74366900,00 | 89600610,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 250000,00 | 250000,00 |
| 210502 | Хоол, хүнс | 74116900,00 | 89350610,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 400000,00 | 1400000,00 |
| 210604 | Урсгал засвар | 400000,00 | 1400000,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 250000,00 | 250000,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 250000,00 | 250000,00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 350000,00 | 480000,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 170000,00 | 300000,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180000,00 | 180000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40540885,60 | 40424003,60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 268000,00 | 100000,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0,00 | 1000000,00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40272885,60 | 39324003,60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6434,00 | 4991193,00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0,00 | 0,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0,00 | 200000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6434,00 | 4791193,00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6434,00 | 4791193,00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **66122311,90** | **-32183904,60** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 0,00 | 0,00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0,00 | 0,00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **66122311,90** | **-32183904,60** |

## 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **401968287,00** | **471502500,00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0,00** | **0,00** |
| **110** | **Орлогын албан татвар** | 0,00 | 0,00 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 0,00 | 0,00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0,00** | **344959600,00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0,00 | 0,00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 0,00 | 344959600,00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 0,00 | 344959600,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **401968287,00** | **126542900,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 393695500,00 | 93411100,00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 393695500,00 | 93411100,00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8272787,00 | 247500,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200000,00 | 0,00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8072787,00 | 247500,00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0,00 | 32884300,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0,00 | 32884300,00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **401968287,00** | **471502500,00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **401968287,00** | **471502500,00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **401961853,00** | **466511307,00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250973960,00 | 304978655,00 |
| 210101 | Үндсэн цалин | 218639083,00 | 267242714,00 |
| 210102 | Нэмэгдэл | 13326831,00 | 9746590,00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 19008046,00 | 27989351,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30122240,00 | 38124400,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20096673,00 | 25924600,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2351549,00 | 3050100,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1946085,00 | 2508115,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 714995,00 | 541785,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5012938,00 | 6099800,00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23742566,00 | 26710170,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4752282,00 | 5065962,00 |
| 210302 | Түлш, халаалт | 9471443,00 | 10773827,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9518841,00 | 10870381,00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11748187,00 | 3167472,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 650000,00 | 787500,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1400000,00 | 380000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 632000,00 | 699972,00 |
| 210404 | Ном, хэвлэл | 466000,00 | 200000,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0,00 | 100000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8600187,00 | 1000000,00 |
| **2105** | **Нормативт зардал** | 75866900,00 | 90300610,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 250000,00 | 250000,00 |
| 210502 | Хоол, хүнс | 74116900,00 | 89350610,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1500000,00 | 700000,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 400000,00 | 1400000,00 |
| 210604 | Урсгал засвар | 400000,00 | 1400000,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 250000,00 | 250000,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 250000,00 | 250000,00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7780000,00 | 480000,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7600000,00 | 300000,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180000,00 | 180000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1078000,00 | 1100000,00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 268000,00 | 100000,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 810000,00 | 1000000,00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6434,00** | **4991193,00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0,00 | 0,00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0,00 | 200000,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0,00 | 200000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6434,00 | 4791193,00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6434,00 | 4791193,00 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0,00** | **0,00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **0,00** | **0,00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0,00** | **0,00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0,00** | **0,00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0,00 | 0,00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0,00** | **0,00** |

| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
|---|---|---|---|
| 14 | **Бусад эх үүсвэр** | 0,00 | 0,00 |
| 145009 | Төрөл бүрийн хандив | | |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 0,00 | 0,00 |
| 250005 | Төлсөн ногдол ашиг | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0,00** | **0,00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0,00 | 0,00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 113 425 000,00 | 126 546 883,01 | 898 886 371,37 | 0,00 | 1 138 858 254,38 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0,00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **113 425 000,00** | **126 546 883,01** | **898 886 371,37** | **0,00** | **1 138 858 254,38** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0,00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0,00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | | 0,00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0,00 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113 425 000,00** | **126 546 883,01** | **898 886 371,37** | **0,00** | **1 138 858 254,38** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **113 425 000,00** | **126 546 883,01** | **898 886 371,37** | **0,00** | **1 138 858 254,38** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **113 425 000,00** | **126 546 883,01** | **898 886 371,37** | **0,00** | **1 138 858 254,38** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0,00 | 0,00 | -32 183 904,60 | 0,00 | -32 183 904,60 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113 425 000,00** | **126 546 883,01** | **866 702 466,77** | **0,00** | **1 106 674 349,78** |

## 4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0,00 | 0,00 | 471255000,00 | 466463807,00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0,00 | 0,00 | 471255000,00 | 466463807,00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0,00 | 0,00 | 471055000,00 | 466263807,00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0,00 | 0,00 | 304995600,00 | 304978655,00 |
| 210101 | Үндсэн цалин | 0,00 | 0,00 | 268276600,00 | 267242714,00 |
| 210102 | Нэмэгдэл | 0,00 | 0,00 | 10758700,00 | 9746590,00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | | |
| 210104 | Урамшуулал | 0,00 | 0,00 | 25960300,00 | 27989351,00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0,00 | 0,00 | 38124400,00 | 38124400,00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0,00 | 0,00 | 25924600,00 | 25924600,00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0,00 | 0,00 | 3050100,00 | 3050100,00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0,00 | 0,00 | 2439900,00 | 2508115,00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0,00 | 0,00 | 610000,00 | 541785,00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0,00 | 0,00 | 6099800,00 | 6099800,00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0,00 | 0,00 | 31484300,00 | 26710170,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0,00 | 0,00 | 5300000,00 | 5065962,00 |
| 210302 | Түлш, халаалт | 0,00 | 0,00 | 16600000,00 | 10773827,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0,00 | 0,00 | 9584300,00 | 10870381,00 |
| 210304 | Байрны түрээс | | | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0,00 | 0,00 | 2920000,00 | 2919972,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0,00 | 0,00 | 300000,00 | 540000,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0,00 | 0,00 | 800000,00 | 380000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0,00 | 0,00 | 520000,00 | 699972,00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0,00 | 0,00 | 200000,00 | 200000,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0,00 | 0,00 | 100000,00 | 100000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0,00 | 0,00 | 1000000,00 | 1000000,00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | | | |
| **2105** | **Нормативт зардал** | 0,00 | 0,00 | 90300700,00 | 90300610,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0,00 | 0,00 | 250000,00 | 250000,00 |
| 210502 | Хоол, хүнс | 0,00 | 0,00 | 89350700,00 | 89350610,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0,00 | 0,00 | 700000,00 | 700000,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0,00 | 0,00 | 1400000,00 | 1400000,00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | | |
| 210602 | Тавилга | | | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | | |
| 210604 | Урсгал засвар | 0,00 | 0,00 | 1400000,00 | 1400000,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0,00 | 0,00 | 250000,00 | 250000,00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 0,00 | 0,00 | 250000,00 | 250000,00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0,00 | 0,00 | 480000,00 | 480000,00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0,00 | 0,00 | 480000,00 | 300000,00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0,00 | 0,00 | 0,00 | 180000,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0,00 | 0,00 | 1100000,00 | 1100000,00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0,00 | 0,00 | 100000,00 | 100000,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0,00 | 0,00 | 1000000,00 | 1000000,00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0,00 | 0,00 | 200000,00 | 200000,00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0,00 | 0,00 | 200000,00 | 200000,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0,0 | 0,0 | 200000,00 | 200000,00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0,00 | 0,00 | 471255000,00 | 471255000,00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0,00 | 0,00 | 438370700,00 | 438370700,00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | | 438370700,00 | 438370700,00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 0,00 | 0,00 | 32884300,00 | 32884300,00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | | | 32884300,00 | 32884300,00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | | |
| **14** | **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| 145005 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 0,00 | 0,00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0,0** | **0,0** | 0,00 | 0,00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 0,00 | 0,00 | 0,00 | 0,00 |
| 610001 | Төсвийн байгууллага | | | | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37,00 | 37,00 | 37,00 | 37,00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1,0 | 1,0 | 1,00 | 1,00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24,0 | 24,0 | 24,00 | 24,00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12,0 | 12,0 | 12,00 | 12,00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 325,00 | 325,00 | 325,00 | 325,00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 325,00 | 325,00 | 325,00 | 325,00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 325,0 | 325,0 | 325,00 | 325,00 |